



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын  
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: С.Гансүх  
Утас: 86479090 Цахим хаяг: [gansukhsa@audit.gov.mn](mailto:gansukhsa@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн  
Захирал: Ч.Энхчимэг  
Утас: 99046494 Цахим хаяг: [enkhchimeg@cptaaudit.mn](mailto:enkhchimeg@cptaaudit.mn)

Аудитор: Б.Бүрэнжаргал  
Утас: 99198743 Цахим хаяг: [Burenjargal@cptaaudit.mn](mailto:Burenjargal@cptaaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс 7038 3793, Цахим шуудан khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас www.audit.mn

2026.02.25 № 01/158  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ДЭЛГЭРМАА ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 3,821.0 мянган төгрөгийн бараа материал, 6,425.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Жилийн эцсийн тооллогоор 5,731.4 мянган төгрөгийн бараа материалыг үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### Бусад асуудлын хэсэг

Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэг нь Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 25 арга хэмжээтэй батлуулж, 88 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a red official stamp. The stamp is rectangular and contains Mongolian text, including the name of the State Audit Agency (АДБОУС) and the date 2024. The signature is written in a cursive style.

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>233,458,137.37</u></b>	<b><u>106,966,703.37</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	156,051,819.85	34,403,644.86
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	156,051,819.85	34,403,644.86
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	156,051,819.85	34,403,644.86
31211	Төрийн сангийн харилцах	156,051,819.85	34,403,644.86
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	216,525.99
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	216,525.99
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	77,406,317.52	72,346,532.52
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,361,200.00	14,152,930.00
35110	Тусгай зориулалттай материал	12,991,050.00	12,991,050.00
35130	Эм боох материал	1,370,150.00	1,161,880.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	63,045,117.52	58,193,602.52
35410	Бичиг хэргийн материал	2,576,550.00	1,720,550.00
35420	Аж ахуйн материал	25,653,372.51	21,268,462.51
35440	Түлш, шатах тослох материал	10,702,390.01	10,540,090.01
35450	Барилгын засварын материал	2,280,000.00	941,500.00
35460	Хүнсний материал	16,877,805.00	20,874,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,955,000.00	2,849,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,611,404,220.17</u></b>	<b><u>1,558,162,953.91</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,611,404,220.17	1,558,162,953.91
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,604,000,720.41	1,550,956,954.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,612,888,363.95	1,612,888,363.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(96,591,780.22)	(133,520,521.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,039,251.80	83,221,937.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,613,425.46)	(54,221,818.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,948,728.94	55,595,552.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,876,748.86)	(25,588,622.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,760,207.26	37,772,112.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,986,132.00)	(26,622,305.54)
39217	Ном	1,432,255.00	1,432,255.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,403,499.76	7,205,999.84
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(592,500.24)	(790,000.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,096,000.00	7,096,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,844,862,357.54</u></b>	<b><u>1,665,129,657.28</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,844,862,357.54</u></b>	<b><u>1,665,129,657.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,844,862,357.54	1,665,129,657.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	97,878,361.33	97,878,361.33

**Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

51101	Өмч: - төрийн	97,878,361.33	97,878,361.33
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,680,081,321.87</b>	<b>1,500,348,621.61</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,680,081,321.87	1,680,081,321.87
51220	Тайлант үеийн үр дүн	-	(179,732,700.26)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,902,674.34	66,902,674.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,844,862,357.54</u></b>	<b><u>1,665,129,657.28</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>736,908,320.19</b>	<b>726,544,650.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>52,652,720.19</b>	<b>10,281,750.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	52,652,720.19	10,281,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,652,720.19	10,281,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,095,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,557,720.19	10,246,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>684,255,600.00</b>	<b>716,262,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	650,255,600.00	678,215,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	650,255,600.00	678,215,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	34,000,000.00	38,047,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,000,000.00	38,047,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>663,091,404.81</b>	<b>906,277,350.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>663,091,404.81</b>	<b>906,277,350.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	663,003,725.26	904,022,044.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	445,205,575.16	637,965,006.49
210101	Үндсэн цалин	289,019,888.28	387,867,354.10
210102	Нэмэгдэл	141,606,709.73	209,671,996.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,088,580.00
210104	Урамшуулал	14,578,977.15	20,337,076.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,644,904.28	77,393,526.51
210201	Тэтгэврийн даатгал	38,445,422.35	52,503,421.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,525,414.67	6,222,470.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,436,297.88	3,111,205.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,280,984.74	3,111,174.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,956,784.64	12,445,256.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,683,300.44	30,134,994.62
210301	Гэрэл, цахилгаан	6,546,418.45	6,504,322.62
210302	Түлш, халаалт	14,717,179.99	20,112,300.00
210303	Цэвэр, бохир ус	3,419,702.00	3,518,372.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,939,100.52	18,287,410.00
210401	Бичиг хэрэг	6,677,150.00	7,614,710.00

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	2,119,116.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,118,700.00	10,672,700.00
210408	Бараа материал акталсны зардал	8,024,134.52	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,693,000.00</b>	<b>55,901,675.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	475,200.00	644,920.00
210502	Хоол, хүнс	42,217,800.00	55,256,755.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,089,900.00</b>	<b>5,158,000.00</b>
210604	Урсгал засвар	5,089,900.00	5,158,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,404,000.00</b>	<b>2,051,500.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,404,000.00	2,051,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>66,343,944.86</b>	<b>77,129,932.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,218,000.00	6,827,006.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,125,944.86	70,302,926.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,679.55</b>	<b>2,255,305.38</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>87,679.55</b>	<b>2,255,305.38</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,679.55	2,255,305.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>73,816,915.38</u></b>	<b><u>(179,732,700.26)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>73,816,915.38</u></b>	<b><u>(179,732,700.26)</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>686,350,600.00</u></b>	<b><u>716,297,900.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,095,000.00</b>	<b>35,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,095,000.00	35,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,095,000.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,095,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>684,255,600.00</b>	<b>716,262,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	650,255,600.00	678,215,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	650,255,600.00	678,215,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>34,000,000.00</b>	<b>38,047,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,000,000.00	38,047,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>585,325,236.99</u></b>	<b><u>835,591,074.99</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>585,325,236.99</b>	<b>835,591,074.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>585,237,557.44</b>	<b>833,335,769.61</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	444,055,456.71	638,181,532.48
210101	Үндсэн цалин	287,869,769.83	388,083,880.09

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	141,606,709.73	209,671,996.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,088,580.00
210104	Урамшуулал	14,578,977.15	20,337,076.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,644,904.28</b>	<b>77,393,526.51</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,445,422.35	52,503,421.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,525,414.67	6,222,470.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,436,297.88	3,111,205.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,280,984.74	3,111,174.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,956,784.64	12,445,256.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,927,420.45</b>	<b>29,972,694.62</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,546,418.45	6,504,322.62
210302	Түлш, халаалт	18,961,300.00	19,950,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,419,702.00	3,518,372.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,819,560.00</b>	<b>59,252,950.00</b>
210502	Хоол, хүнс	31,819,560.00	59,252,950.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,984,900.00</b>	<b>5,819,500.00</b>
210604	Урсгал засвар	4,984,900.00	5,819,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,404,000.00</b>	<b>2,051,500.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,404,000.00	2,051,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,401,316.00</b>	<b>20,664,066.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,060,116.00	14,705,356.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,341,200.00	5,958,710.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,679.55</b>	<b>2,255,305.38</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>87,679.55</b>	<b>2,255,305.38</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,679.55	2,255,305.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>101,025,363.01</u></b>	<b><u>(119,293,174.99)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,276,000.00</b>	<b>2,355,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,276,000.00</b>	<b>2,355,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,276,000.00</b>	<b>2,355,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,276,000.00	2,355,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,276,000.00)</u></b>	<b><u>(2,355,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>99,749,363.01</b>	<b>(121,648,174.99)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>56,302,456.84</b>	<b>156,051,819.85</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>156,051,819.85</b>	<b>34,403,644.86</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>97,878,361.33</b>	<b>65,899,409.59</b>	<b>1,606,873,171.24</b>	<b>1,770,650,942.16</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(608,764.75)	(608,764.75)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>97,878,361.33</b>	<b>65,899,409.59</b>	<b>1,606,264,406.49</b>	<b>1,770,042,177.41</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	1,003,264.75	-	1,003,264.75
Тайлант үеийн үр дүн	-	-	73,816,915.38	73,816,915.38
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>97,878,361.33</b>	<b>66,902,674.34</b>	<b>1,680,081,321.87</b>	<b>1,844,862,357.54</b>
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>97,878,361.33</b>	<b>66,902,674.34</b>	<b>1,680,081,321.87</b>	<b>1,844,862,357.54</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>97,878,361.33</b>	<b>66,902,674.34</b>	<b>1,680,081,321.87</b>	<b>1,844,862,357.54</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(179,732,700.26)	(179,732,700.26)
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>97,878,361.33</b>	<b>66,902,674.34</b>	<b>1,500,348,621.61</b>	<b>1,665,129,657.28</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан:

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	821,987,700.0	678,250,400.0	143,737,300.0	82.5
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	684,212,300.0	678,215,400.0	5,996,900.0	99.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	684,212,300.0	678,215,400.0	5,996,900.0	99.1
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	137,775,400.0	35,000.0	137,740,400.0	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.0	35,000.0	35,000.0	50.0

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	137,705,400.0	-	137,705,400.0	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	821,987,700.0	799,898,575.0	22,089,125.0	97.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	821,987,700.0	799,898,575.0	22,089,125.0	97.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	821,987,700.0	799,898,575.0	22,089,125.0	97.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	648,255,795.0	638,181,532.5	10,074,262.5	98.4
210101	Үндсэн цалин	417,527,200.0	388,083,880.1	29,443,319.9	92.9
210102	Нэмэгдэл	217,072,900.0	209,671,996.1	7,400,903.9	96.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,088,580.0	(20,088,580.0)	
210104	Урамшуулал	13,655,695.0	20,337,076.3	(6,681,381.3)	148.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	75,034,105.0	77,393,526.5	(2,359,421.5)	103.1
210201	Тэтгэврийн даатгал	51,027,601.0	52,503,421.0	(1,475,820.0)	102.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,003,701.0	6,222,470.0	(218,769.0)	103.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,002,801.0	3,111,205.0	(108,404.0)	103.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,002,801.0	3,111,174.0	(108,373.0)	103.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,997,201.0	12,445,256.5	(448,055.5)	103.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	69,447,000.0	59,252,950.0	10,194,050.0	85.3
210502	Хоол, хүнс	69,447,000.0	59,252,950.0	10,194,050.0	85.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,575,400.0	2,051,500.0	1,523,900.0	57.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,575,400.0	2,051,500.0	1,523,900.0	57.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,675,400.0	23,019,066.0	2,656,334.0	89.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,557,800.0	17,060,356.0	2,497,444.0	87.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,117,600.0	5,958,710.0	158,890.0	97.4
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	156,051,819.9	(156,051,819.9)	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	34,403,644.9	(34,403,644.9)	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	16.0	16.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8.0	8.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	7.0	7.0	-	100.0

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан:**

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	38,047,500.0	35,792,194.6	2,255,305.4	94.1
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	38,047,500.0	35,792,194.6	2,255,305.4	94.1
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,047,500.0	35,792,194.6	2,255,305.4	94.1
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	38,047,500.0	35,792,194.6	2,255,305.4	94.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	38,047,500.0	35,792,194.6	2,255,305.4	94.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	38,047,500.0	35,792,194.6	2,255,305.4	94.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,047,500.0	29,972,694.6	2,074,805.4	93.5
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.0	6,504,322.6	2,495,677.4	72.3
210302	Түлш, халаалт	20,000,000.0	19,950,000.0	50,000.0	99.8
210303	Цэвэр, бохир ус	3,047,500.0	3,518,372.0	(470,872.0)	115.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,000,000.0	5,819,500.0	180,500.0	97.0
210604	Урсгал засвар	6,000,000.0	5,819,500.0	180,500.0	97.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 6,673.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 475.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,731.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 467.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 6,198.5 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 7,957.1 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

**3.1 Аудитын залруулга**

Тус онд 475.3 мянган төгрөгийн эм бэлдмэл, бусад хангамжийн материалыг анхан шатны баримтаар зарлагдсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй эцсийн үлдэгдлийг илүү тайлагнасныг аудит явцад залруулав.

**3.2 Төлбөрийн акт**

Цагийн тооцооны хуудсанд илүү цагийн бүртгэлгүй ажилтанд илүү цаг бодож 467.1 мянган төгрөг олгосон нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3 дугаар зүйлийн 3.1-т “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар,

долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй ба “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

### 3.3 Албан шаардлага

Жилийн эцсийн тооллогоор 5,731.4 мянган төгрөгийн эм бэлдмэл, бичиг хэрэг, бусад хангамж, материалуудын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2. “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүй ба “Бодитой оршин байх ба тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрлэлт: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

### 3.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй болно.

Дээрх төлбөрийн актыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын [www.Fas.audit.mn](http://www.Fas.audit.mn) цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эм бэлдмэл, бусад хангамжийн материалыг анхан шатны баримтаар зарлагдсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй эцсийн үлдэгдлийг илүү тайлагнасан.	1	475.3					1	475.3		
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>475.3</b>					<b>1</b>	<b>475.3</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жилийн эцсийн тооллогоор эм бэлдмэл, бичиг хэрэг, бусад хангамж, материалуудын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй	1	5,731.4			1	5,731.4						
2	Цагийн тооцооны хуудсанд илүү цагийн бүртгэлгүй ажилтанд илүү цаг бодож олгосон	1	467.1	1	467.1								
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,198.5</b>	<b>1</b>	<b>467.1</b>	<b>1</b>	<b>5,731.4</b>						

**5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

№ 48/А2270648/ХАА-2026/  
042/АА-СН А-ИШЗ

Мөрөн сум

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагийн тооцооны хуудсанд илүү цагийн бүртгэлгүй ажилтанд 467,078.60 /дөрвөн зуун жаран долоо мянга далан найм төгрөг жаран мөнгө/ төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.1-т "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цагийн тооцооны хуудсанд илүү цагийн бүртгэлгүй ажилтанд олгосон илүү цагийн нэмэгдэл хөлс 467,078.60 /дөрвөн зуун жаран долоо мянга далан найм төгрөг жаран мөнгө/ төгрөгийг Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогч Ө.Баасанхүүгээс гаргуулж Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup> нотлох баримтын хамт ирүүлэхийг Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Ч.Дэлгэрмаа), нягтлан бодогч (Ө.Баасанхүү) нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

"СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ"ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

720090061 9070605

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, 303 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

№ 48/А2270648/ТӨА-2026/  
042/АА-СИА-ИШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн бараа материалын тооллого, бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн болон зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын тооллого, бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хийгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>-т нотлох баримтын хамт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч(Ч.Дэлгэрмаа), нягтлан бодогч (Ө.Баасанхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ"ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

1720090001 9070605

6724021020